

**“КАТА” ХХК-ИЙН УЛААНБААТАР ХОТ, НАЛАЙХ
ДҮҮРЭГ, 5-Р ХОРООНЫ НУТАГТ БАЙРЛАХ БАЯН ТАЛ
НЭРТЭЙ “ЭЛС ХАЙРГАНЫ ОРД АШИГЛАХ” ТӨСЛИЙН
2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

Улаанбаатар хот,

2025 он

ОРШИЛ

Улаанбаатар хот Налайх дүүргийн 5-р хорооны нутаг дэвсгэрт Ката ХХК нь 21/М047 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй элс хайрганы ордыг ашиглах төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг Их зос ХХК нь 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 13/2863 тоот ерөнхий үнэлгээний дүгнэлтийн дагуу боловсруулж Байгаль орчин, аялал жуулчлалын яамны байгаль орчны стратеги үнэлгээ, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ, уул уурхай, хүнд үйлдвэрийн төслийн үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2022 оны 06 дугаар сард тайланг хэлэлцүүлэн батлуулсан.

Тус 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг дээрх байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд үндэслэн боловсруулсан болно.

Энэхүү төлөвлөгөө нь үндсэн 2 бүлэг, оршил, дүгнэлт болон хавсралт материал зэргээс бүрдэнэ.

ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1.1 ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр	Элстэйн голын элсний ордын баруун салааны элсний орд /21/М047/
Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллага	- Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: “Ката” ХХК - Улсын бүртгэлийн дугаар: 9011535042 - Регистрийн дугаар: 5931312 - Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 4-р хороо, 15-р хороолол, 64-8 тоот - Утас: 99111840

1.1.1 Төслийн байршил, хэрэгжих орчны тойм зураг

Төсөл хэрэгжүүлэгч Ката ХХК нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн 5 дугаар хоорооны нутаг Баянтал нэртэй газарт байрлах Элстэйн голын элсний ордын баруун салааны элсний орд нь 161.0 га талбай бүхий 21/М047 тоот 15 жил ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг юм.

Уг орд нь Улаанбаатар хотоос зүүн зүгт 54 орчим км-т Налайх дүүргээс зүүн зүгт 18 км, Улаанбаатар- Багануурыг холбосон хатуу хучилттай авто замаас урагшаа 4.5 км-т Налайх дүүргийн 5-р хорооны нутаг дэвгэрт оршино. Талбайн солбицолын цэгүүдийг Хүснэгт 1-д, байршлыг Зураг 1-1-д тус тус үзүүлэв.

Хүснэгт 1. Төслийн талбайн солбицол

Цэг ¹	Х	Ү	Талбайн хэмжээ
1	107° 32' 15,0"	47° 45' 18,2"	161,0 га
2	107° 30,1' 44"	47° 45' 18,2"	
3	107° 30,1' 44"	47° 45' 44,76"	
4	107° 31' 20,44"	47° 45' 44,76"	
5	107° 31' 20,44"	47° 45' 25,77"	
6	107° 32' 15"	47° 45' 25,77"	

Зураг 0-1. Төслийн талбайн байршил

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ката ХХК нь уурхайн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг илрүүлэх, тэдгээрийн үр дагаврыг тогтмол хянах, хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэд нутгийн иргэдийн оролцоог хангах, дэмжих зарчим баримтлан ажиллах үүрэгтэй. Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд Ката ХХК -ийн Элсний ордын олборлолтын ажил болон бусад үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн бөгөөд төсөл хэрэгжүүлэгч уурхайн үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш жил бүр энэхүү үнэлгээгээр тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, тэдгээрийг арилгах бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай. Ингэхдээ байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дагавар, бодит байдалтай уялдуулан улам баяжуулж, сайжруулан мөрдлөг болгох хэрэгтэй. Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан БОУАӨЯ-д хүргүүлж дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг батлуулах үүрэгтэй.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөөг нөлөөлөлд өртөж болзошгүй байгалийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр авч үзэж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг 1 жилээр тооцлоо.

1.2 Эрхзүйн үндэслэл ба гол шаардлага

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм. БОМТ нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсаныг баримтлан БОХТ, ОХШХ-ийг боловсруулав.

Нөгөө талаас төслийг хэрэгжүүлэгч Ката ХХК нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын буюу одоогийнхоор БОАЖЯ-ны нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ. Хэрвээ Ката ХХК байгаль хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ хангалттай биелүүлж, уурхайн ашиглалтын жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг биелүүлсэн бол Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3-т заасан

“Ката” ХХК

хаалтын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн явцыг үндэслэн мөн хуулийн 9.10-т зааснаар хуримтлагдсан хөрөнгийг тодорхой хуваарийн дагуу буцаан олгохоор зохицуулагдсан.

Төсөл хэрэгжүүлэгч Ката ХХК тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан БОАЖЯ-д хүргүүлж дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг батлуулах үүрэгтэй.

БОМТ-г боловсруулахдаа Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2019 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн А-618 дугаар тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, “Байгаль орчны стратегийн болон хуримтлах нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ийн 4-р хэсэг болох Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал, зэргийг удирдлага болголоо.

1.3 Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын хураангуй

Элсний карьер төслийн БОМТ-г Байгаль орчин ногоон хөгжлийн яамны сайдын 2019 оны А-618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, “Байгаль орчны стратегийн болон хуримтлах нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ийн 4-р хэсэг болох Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлалд заасны дагуу хийж гүйцэтгэсэн ба БОМТ-ний хүрээнд 2025 онд **19.45 сая.төг буюу арван есөн сая дөрвөн зүүн тавин мянган төгрөг** зарцуулахаар төлөвлөвөө.

Хүснэгт 2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө		Нийт зардал (сая төг)
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	Сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээний төлөвлөгөө	3.0.
2		Нөхөн сэргээлт төлөвлөгөө	4.61
		Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих төлөвлөгөө	0.94
3		Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	4.1
4		Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	-
5		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	2.0
6		Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	1.2
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	3.6
Нийт зардал			19.45

1.4 Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд (Төрийн мэдээлэл, 2012 оны 22 дугаар) аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар заасан.

“Ката” ХХК

Хуулийн дээрх шаардлагын дагуу Элсний карьер ашиглах төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлыг хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулав.

БОМТ-ний хэрэгжилтийн тайланг заасан хугацаанд гаргаж төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн захиргаа, ойр орчмын нутаг дэвсгэр дэх иргэдэд танилцуулах тэдний саналыг нэгтгэн тусгах ажлыг зохион байгуулах, оролцогч болон сонирхогч талуудад мэдээллийг ил тод байлгах арга хэмжээг авсан байх шаардлагатай.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг нэг жилээр боловсруулсан ба нийт 3.0 сая.төг буюу гурван сая төгрөг зарцуулах тооцоолол гарсан болно.

**БАЯН ТАЛ НЭРТЭЙ ЭЛС ХАЙРГАНЫ ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

“Ката” ХХК

Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Давтамж	Биелэлт	Баримтлах стандарт, аргачлал
Агаарын чанар					MNS ISO4227-2002, “Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө” MNS4585-2016, “Агаарын чанар. MNS5885-2008, “Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. MNS6063-2010, “Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ” MNS4990-2000, “ХААЭА. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага” Хорт утааны бохирдлын стандарт (MNS 5013:2003 бензин хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид, MNS 5014:2003 дизель хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид
Уурхайн олборлолт болон тээвэрлэлт, элс хайрга шигшин ангилах хэсгээс тоосжилт үүсэх	Уурхайн олборлолт, ангилан ялгах хэсгээс тоосжилт үүсэхээс сэргийлэн тоос дарагч бодис цацах,	Олборлолт явуулах талбай болон тээвэрлэлтийн зам	Салхи ихээр босдог хавар, намрын улиралд 7 хоногт 1-2 удаа	Хийгдсэн	
Хүнд даацын машин механизмаас гарах хорт хий агаарын чанарт сөргөөр нөлөөлж, агаарыг бохирдуулах	Стандарт шаардлагад нийцсэн тээврийн хэрэгслийг ашиглах, хяналт тавих, засвар үйлчилгээг тогтмол хугацаанд хийх,	Хүнд даацын машин механизм	Жилд нэг удаа	Хийгдсэн	
Шимт хөрсний овоолго	Шимт хөрсний овоолгыг ТЭЗҮ, УАТнд тусгасаны дагуу төлөвлөх, хамгийн бага талбайд овоолго хийхээр төлөвлөх	Төслийн талбайд	-	Төлөвлөлтийн дагуу хийгдсэн	
Хөрсөн бүрхэвч					

**БАЯН ТАЛ НЭРТЭЙ ЭЛС ХАЙРГАНЫ ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

“Ката” ХХК

Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Давтамж	Биелэлт	Баримтлах стандарт, аргачлал
Шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас хөрс бохирдож болзошгүй.	Асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг авах, саармагжуулах хэрэгслийг төслийн талбайд бэлэн байлгах	Агуулах, засварын газар	Үйл ажиллагааны туршид	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөнд тусгасгданы дагуу хийгдсэн	MNS3297-1991, “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм” MNS4919-2000, “Эвдэрсэн газрын хажуугийн налуу. Техникийн шаардлага” MNS5850-2008, “Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS5914-2008, “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн нэр томьёо, тодорхойлолт” MNS5915-2008, “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал” MNS5917-2008, “Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” MNS5916-2008, “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” MNS5918-2008, “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага”
Хог хаягдлаар бохирдох	Хогийн цэгийн орчин тойрны хөрсний бохирдлыг хянаж байх	Хогийн цэг		Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсаны дагуу хийгдсэн	

**БАЯН ТАЛ НЭРТЭЙ ЭЛС ХАЙРГАНЫ ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

“Ката” ХХК

Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Давтамж	Биелэлт	Баримтлах аргачлал стандарт,
Хөрсөн бүрхэвч доройтох, элэгдэл эвдрэл үүсэх	Төслийн объектууд хоорондын явган хүний замыг засаж сайжруулах	Зам талбай	Нэг удаа	хийгдсэн	
Усан орчин					
ШТМ болон химийн бодисын асгаралт гүний усруу нэвчих	ШТМ болон химийн бодисын асгаралт бий болсон тохиолдолд хэрэглэх зүйлс болон арга хэмжээг дагаж мөрдөх	Төслийн талбай	Улиралд нэг удаа шалгаж, материалуудыг бэлтгэх	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийгдсэн	
Унд ахуйн ус бохирдох	Унд ахуйд хэрэглэдэг усны эрүүл ахуйг хангаж хэрэглэх	Худаг	Жилд 2 удаа	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу хийгдсэн	
Гүний усны хэт их хэрэглээнээс усны түвшин буурах	Зам талбайн тоос дарахад гүний усыг хэмнэлттэй ашиглаж, тоос дарагч зориулалтын бодис ашиглах, услах шаардлагатай тохиолдолд усалгааг	Тээврийн зам	-	Усалгааг тогтмол хийгддэг	

**БАЯН ТАЛ НЭРТЭЙ ЭЛС ХАЙРГАНЫ ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

“Ката” ХХК

Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Давтамж	Биелэлт	Баримтлах аргачлал стандарт,
	үүрээр газрын хөрсний температур хамгийн бага үед цаг агаарын мэдээнд уялдуулж услах				
Биологийн олон янз байдал					
Олборлолт болон тээвэрлэлт	Шимт хөрс хуулах талбайн ургамлан бүрхэвчийн мэдээллийг цуглуулах	Төслийн талбай	Жил бүрийн 5-6 сард	Хийгдэж байгаа	MNS5918-2008, “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага” Байгаль орчны хамгаалах тухай хууль Байгалийн ургамлын тухай хууль Ургамал хамгааллын тухай хууль Амьтны тухай хууль
Уурхайн карьерт мал амьтан орох	Ил уурхайн хашааны бүрэн бүтэн байдалд үзлэг хийж, мал амьтан орохоос сэргийлэх	Төслийн талбай	Долоо хоног бүр	Үзлэг тогтмол хийгддэг	
Уурхайн нөлөөллөөр биологийн олон янз байдал хомсдох	Уурхайн эргэн тойронд үзэгдсэн амьтдын зураг, ул мөр зэргийг тэмдэглэж авч амьтдын мэдээллийн сан үргэлжлүүлэх		Жилд 1 удаа	Тогтмол хийгддэг	
	Хавар намрын улиралд уурхайн орчмын амьтдад идэш тэжээл, ус зэргийг бэлдэж тавих		Жилд 1 удаа	Одоогоор хийгдээгүй	
Хог хаягдлыг эмх замбараагүй	Ахуйн гаралтай хог хаягдлын түр цэгийг	Хогийн цэг	Жилд 1 удаа	Хог хаягдлын менежментийн	

БАЯН ТАЛ НЭРТЭЙ ЭЛС ХАЙРГАНЫ ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

“Ката” ХХК

Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Давтамж	Биелэлт	Баримтлах аргачлал стандарт,
хаяснаас болж амьтдын амьдрах орчин доройтох, бохирдох	салхины ноёлох чиглэлийн дор байгуулж, хог хаягдлын ангилан ялгаж, тогтмол хугацаанд зайлуулах, хогийн цэгийг халдваргүйжүүлж байх			төлөвлөгөөний дагуу хийгдэж байгаа	
Төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт сөргөөр нөлөөлөх	Төсөл хэрэгжих орчны үндсэн ургамалжилт, нэн ховор болон ховор ургамлыг танин мэдэх, тэдгээрийн ач холбогдлыг уурхайн ажилчид болон нутгийн иргэдэд таниулах үүднээс ургамлын судалгааг мэргэжлийн шинжээчээр хийлгэх	Төслийн талбайд	Жилд 1 удаа	Хийгдэж байгаа	
	Судалгаагаар тогтоосон ургамлуудаар мэдээллийн сан үүсгэн, ургамлыг таних, түүний ач холбогдол бүхий зураг тайлбартай мэдээллийн самбар	Төслийн талбайд	Жилд 1 удаа	Хийгдэж байгаа	

БАЯН ТАЛ НЭРТЭЙ ЭЛС ХАЙРГАНЫ ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

“Ката” ХХК

Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Давтамж	Биелэлт	Баримтлах аргачлал	стандарт,
	хийж байршуулах					

**БАЯН ТАЛ НЭРТЭЙ ЭЛС ХАЙРГАНЫ ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

“Ката” ХХК

1.4.1 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Төсөл хэрэгжүүлэгч нөхөн сэргээлтийн ажлыг тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөөтэй уялдуулан хийж гүйцэтгэх нь зүйтэй юм. Тэрбум модны тоог өөрийн уурхайн байршиж буй байгалийн бүсчлэлд харгалзуулан MNS 5918:2008 Байгаль орчин, эвдэрсэн газрын ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлагын дагуу 500-3333 ширхэг тарихаар, зарцуулах зардлыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 07 сарын 09-ний өдрийн А/172, 116 дугаар “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний зардлын нормативыг шинээр болон шинэчлэн батлах тухай” тушаалд зааснаар тооцно.

Хүснэгт 4. Нөхөн сэргээлтийн арга хэмжээний зардал

	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн хэмжээ	сэргээлтийн арга	Шаардагдах хөрөнгө /мян.төг/			Баримтлах эрх зүйн баримт бичиг
				Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Зардлын хэмжээ /сая.төг/	
1	Техникийн нөхөн сэргээлт	Уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр эвдрэлд өртсөн талбайд овоолгыг налуулан хэлбэршүүлэх, техникийн нөхөн сэргээлт хийх	га		5.38	3.21	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал Ашигт малтмалын ордыг ил уурхайгаар ашиглах явцад үүсэх газрын хэвлийг нөхөн сэргээж ургамалжуулах заавар MNS 4916:2000 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсийг хуулах MNS 4917:2000
2	Биологийн нөхөн сэргээлт	Уурхайн эвдрэлд өртсөн нийт талбайд биологийн нөхөн сэргээлт хийх	га		5,88	1.4	Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS 5914:2008 Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916:2008 Уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэн эвдэрсэн газрыг нөхөн сэргээх техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008
3	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих	ОНБОГ-аас заасан газарт мод суулгана	ш		50	1.04	Эвдэрсэн газрын хажуугийн налуу техникийн шаардлага MNS 4920:2000 Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийхэд тавигдах ерөнхий шаардлага MNS 0017-5-1-19-92 Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага MNS 4918:2000 Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс техникийн шаардлага MNS 4919:2000 Эвдэрсэн газрыг ургамалжуулах MNS 5918:2008
4	Нийт зардал					5.65	

1.4.2 Нүүлгэн суурьшуулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн кадастрын зураг болон хээрийн судалгааны явцад төслийн талбайд айл өрх, үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж байхгүй байна. Иймээс “Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө”-г тусгайлан боловсруулах шаардлагагүй болно.

1.4.3 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд доорх ажлуудыг хийнэ.

- ✓ Сонгон авсан ургамлын зүйлүүдийг дүйцүүлэн хамгаалахаар сонгон авсан газар нутагт шилжүүлэн суулгах, үрийн генийн сантай болох, тарималжуулах туршилт үйлдвэрлэлийн ажлыг зохион байгуулах
- ✓ Амьтдын амьдрах таатай орчныг бий болгох: Зэрлэг амьтдад зориулсан автомат өргүүрт уст цэг байгуулах
- ✓ Биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлэх (өвөл болон хаврын идэш тэжээл хомс үед зэрлэг амьтдад өвс, хужир тавих), зэрлэг амьтдын тогтмол ажиглагддаг, үржлийн үед чухал ач холбогдолтой газруудыг тэмдэгжүүлэх
- ✓ Хулгайн антай тэмцэх. Дүйцүүлэн хамгаалахаар сонгон зүйлүүд болон тэдгээрийн экологийн ач холбогдол, ирвэс идэш тэжээл хомсодсон үед л гэрийн мал руу дайрдаг талаар иргэд, малчид, уурхайн ажилчдад байгаль хамгаалах ТББ-уудтай хамтран сургалт зохион байгуулах, сурталчилгаа хийх.

“Ката” ХХК

Хүснэгт 5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

1.4.4 Соёлын өвийг хамгаалах арга хэмжээ

Уурхайн ашиглалтын талбай орчимд хийгдсэн судалгаагаар ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор бүртгэгдээгүй. Гэвч уурхайн газар шорооны ажлын явцад соёл өв олохыг үгүйсгэж болохгүй. Тиймээс уурхай үйл ажиллагааны явцад соёлын өв олдсон тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30.4-т заасны дагуу олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор сум, дүүргийн бүртгэл мэдээллийн санд заавал бүртгүүлнэ.

Хэрэв уурхай ашиглалтын явцад соёлын өв илэрсэн олдсон тохиолдолд уурхайн үйл ажиллагааг түр зогсоон холбогдох мэргэжлийн байгууллагаар авран хамгаалах малтлага судалгааг хийлгэх нь зүйтэй.

1.4.5 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Элсний карьер нь дотоод аюулгүй ажиллагаандаа OHSAS 18000 буюу ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны журмыг нэвтрүүлэн ажиллах нь зүйтэй. Төсөл хэрэгжүүлэгч уурхайн гэнэтийн ослын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө болон ХАБЭА-н арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийт 14.5 сая.төг буюу арван дөрвөн сая таван зуун мянган төгрөг зарцуулах шаардлагатай.

Хүснэгт 6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Нөлөөллөөс зайлсхийх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Биелэлт	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Байгалийн давагдашгүй хүчин зүйлээс үер, аянга цахилгаан буух, шороон шуурга, гал түймэр болох	Байгалийн гамшгийн үед авах арга хэмжээний зааварчилгааг ажилчдад өгөх, аянга цахилгааны газардуулах тоноглолуудын бүрэн бүтэн байдлыг шалгах, орчны тоосжилтоос сэргийлж ажилчдыг хөдөлмөр хамгааллын хэрэгслээс хангах	Төслийн талбай	Тогтмол хийгдэж байгаа	Жилд нэг удаа
Нефт болон химийн аюултай бодис асгарах	Ашиглалт, тээвэрлэлт, хадгалалт зэрэгт анхаарал хандуулж холбогдох журам боловсруулан мөрдөж ажиллах шаардлагатай.	Төслийн талбай, агуулах	Тогтмол хийгдэж байгаа	Төслийн хугацаанд байнга
	Химийн бодисын ашиглалт, хадгалалтаар ажилчдад сөрөг нөлөө үүсэхээс сэргийлж эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах,			Жилд нэг удаа
Гэнэтийн осол аваар гарах	Уурхайн нийт ажилчдад ХАБЭА сургалт зохион байгуулж, уурхайн эрсдэлийн менежментийн дагуу ажиллахыг зааварчлах, дадлагажуулах	Ажилчид	Тогтмол хийгдэж байгаа	Жилд 2 удаа

1.4.6 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Ахуйн хог хаягдлыг (цаас, баглаа боодлын хайрцаг, хуванцар сав, металл, төмөр, шил, нийлэг материал г.м) ангилан түр хадгалах хогийн саванд цуглуулна. Ахуйн болон бусад хатуу хог хаягдлыг ангилсны дараагаар дахин ашиглах хатуу хог хаягдлыг тээвэрлэн хоёрдогч түүхий эд авдаг төвлөрсөн цэгт тушаана. Ашигласан тосыг битүүмжлэл сайтай саванд цуглуулан дахин боловсруулах үйлдвэрт тээвэрлэн хүргэнэ. Бусад хатуу хог хаягдлыг ялган, зориулалтын саванд цуглуулан, тусгайлан тоноглогдсон тээврийн хэрэгслээр зөөж тогтоосон цэгт хаяна.

Хаягдал зайлуулах нүх/савыг сард нэгээс доошгүй удаа ариутгах ба бие засах газар, шүршүүрийг өдөр бүр цэвэрлэж, ариутгана. Төсөл хэрэгжиж дууссаны дараагаар бохир усны нүх, сав, бие засах газрыг ариутган булж тэгшлэн нөхөн сэргээнэ. Бага агуулгатай эфелийн овоолгын бүртгэл мэдээллийг хөтөлж уурхайн хаалт нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд MNS 5917:2008 стандартад заасны дагуу 20 градусаас ихгүй налуутайгаар хэлбэршүүлж орон нутгийн удирдлагад холбогдох газрын зураг, мэдээллийн хамт хүлээлгэн өгнө.

Ажилчдын хариуцлагагүй байдал, машин техникийн эвдрэл гэмтэл зэргээс хөрсөнд нефтийн бүтээгдэхүүн алдагдсан тохиолдолд бохирдсон хөрсийг хуулан авч, тусгаарлагч гадаргуу дээр овоолон, 18-22%-ийн хлорт уусмалаар бороожуулж, нефтийн бүтээгдэхүүний агуулга 0.07 мг/кг-аас ихгүй, 4 этилт хар тугалганы хэмжээг 0.05 мг/кг-аас ихгүй байх нөхцөлийг хангасан тохиолдолд буцаан байршуулна.

Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Хог хаягдлын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актуудаар зохицуулагдаж байна.

Энэхүү төслийн хүрээнд алт олборлох явцад төсөл хэрэгжүүлэгч дараах эрх эзэлж үүрэг хүлээнэ.

- Хог хаягдлын талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах;
- Хог хаягдлыг дахин боловсруулах арга технологийг нэвтрүүлэх;
- Үйлдвэрлэл, үйлчилгээний төрлөөс хамаарч хог хаягдлыг төрөлжүүлж, хог хаягдал хадгалах түр цэгт ангилан хаях, хог хаягдлын талаарх мэдээллийг төрийн болон нутгийн захиргааны байгууллагад үнэн зөв мэдээлэх;
- Хог хаягдлын талаарх дүрэм, журам, стандартын шаардлагыг хангаж ажиллах;
- Хог хаягдлыг ангилан хаях талаар зохих мэдлэгийг ажилтандаа эзэмшүүлж, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллах;
- Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан биелэлтийг хангаж ажиллах;
- Аюултай хог хаягдлыг бусад төрлийн хог хаягдалтай хамт тээвэрлэхгүй байх;
- Хог хаягдлыг зориулалтын саванд хийж, зориулалтын

хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, ШТМ асгарсан тохиолдол тухай бүрд нь холбогдох албан тушаалтанд мэдээлэх, уурхайн дотоод журамд хог хаягдлыг ангилах талаар тусган ажиллана. Төсөл хэрэгжих хугацаанд үүссэн хатуу хог хаягдлыг дээрх зөвлөмжийн дагуу зайлуулж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авна.

**БАЯН ТАЛ НЭРТЭЙ ЭЛС ХАЙРГАНЫ ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

“Ката” ХХК

Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын төрөл	Хог хаягдлыг устгах	Биелэлт	Нийт зардал /сая.төг/
Ахуйн хэрэглээний хог хаягдал	Ажилчдын хэрэглээнээс гарах хог хаягдлын нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлэн сард 1-2 удаа Мандал-Овоо сумын нэгдсэн хогийн цэгт зөөвөрлөн хаях	Гэрээний дагуу зөөвөрлөдөг	Үйл ажиллагааны зардалд тусгах
	Хоол хүнсний хаягдлыг ашиглан компост хийх талаар судлах	Төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө	0.5 сая ₮
	Хог хаягдлын бүртгэл хөтлөх, тайлан мэдээг гаргах	Хийгдэж байгаа	Үйл ажиллагааны зардалд тусгах

1.4.7 Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Төсөл хэрэгжүүлэгч болох Ката ХХК нь уурхайн үйл ажиллагааны туршид доорх хүснэгтэд үзүүлсэн арга хэмжээг тухай бүрд авч хэрэгжүүлэх шаардлагатай. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж орон нутагтайгаа хамтран ажиллах зүйтэй.

Хүснэгт 8. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Давтамж	Биелэлт
1.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх	Төслийн хугацаанд	Хийгдсэн
2.	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 2 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах.	Төслийн нийт хугацаанд	Хийгдсэн
3.	Уурхайн ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө	Хийгдсэн
4.	Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулах. Ажилчдыг ажлын онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалалтын хэрэгслээр тогтмол хангах, Хордлого тайлах хүнс, эмээр хангаж байх	Төслийн нийт хугацаанд	Хийгдсэн
5.	Галын аюулаас хамгаалах хэрэгсэл, эрүүл ахуйн хэрэгслээр хангах	Төслийн үйл ажиллагаа эхлэхээс	Хийгдсэн
6.	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОУАӨЯ болон аймгийн ЗДТГ-т хүргэн өгч байх	Жил бүрийн 12 сард	Хийгдсэн
7.	Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх, сургалт аян, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион	Төслийн хугацаанд	Хийгдсэн

БАЯН ТАЛ НЭРТЭЙ ЭЛС ХАЙРГАНЫ ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

“Ката” ХХК

	байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах		
8	Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж орон нутагтайгаа хамтран ажиллах	-	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгав

1.5 “Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зааснаар Элсний карьер ашиглах төслийг хэрэгжүүлэхдээ тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг төсөл хэрэгжүүлэгч Ката ХХК-д өгөгдсөн. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсан байна.

Хуулийн дээрх заалтыг удирдлага болгон төслийг хэрэгжүүлэх явцад Ката ХХК-аас байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон Байгаль орчин ногоон хөгжлийн яамны сайдын 2019 оны А-618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, “Байгаль орчны стратегийн болон хуримтлах нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ийн 4-р хэсэг болох Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлалд заасны дагуу байгалийн бүрдэл тус бүрээр энэхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг (ОХШХ) боловсруулав.

**БАЯН ТАЛ НЭРТЭЙ ЭЛС ХАЙРГАНЫ ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

“Ката” ХХК

Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээ явуулах арга хэлбэр, хэрэглэх багаж төхөөрөмж	Зардал, сая.төг /1 жил/	Баримтлах стандарт ба арга, аргачлал
Агаарын чанар					
Нарийн ширхэглэгт тоосонцор PM2.5, PM10	- Ил уурхайн олборлолтын орчимд - Тээвэрлэлтийн замын орчимд - Энгийн хаягдлын цэг - Аюултай хог хаягдлын түр цэг - Түлшний агуулах - Ажилчдын хотхон	Хөндлөнгийн хяналт шинжилгээг жилд нэг удаа			MNS3113:1981. Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага MNS0017-2-3-16:1988. Агаар мандал-Хот, суурингийн агаарын бохирдлын шинжилгээ MNS3384:1982. Агаар мандал-Агаарын дээжилт шинжилгээ MNS3113:1981. Хорт утааны ялгаралтыг хэмжих арга MNS5061:2001. Нүүрс хүчлийн хий-CO2 тодорхойлох эзлэхүүний арга MNS0012-014:1991. Ажлын байрны агаар-Бичил орчинг шинжлэх арга MNS0012-1-015:1987. Чимээ шуугиан-Ажлын байрны чимээ шуугианыг хэмжих арга MNS0017.2.5.12:8988. Хүхэрлэг хий-SO2 шинжлэх TXM буюу аэрозалины арга MNS0017.2.5.11-1998. Азотын давхар исэл
Хийн хяналт: CO, NO2, SO2	- Ил уурхайн олборлолтын орчимд - Тээвэрлэлтийн замын орчимд - Энгийн хаягдлын цэг - Аюултай хог хаягдлын түр цэг - Түлшний агуулах - Ажилчдын хотхон		Салхины зонхилох чиглэл болон эх үүсвэрүүдийн байршил нөлөөллийн төвшин зэрэгт тулгуурлан уурхайн орчим дахь агаар бохирдуулагчийн тархалтыг гаргахад төлөөлөх чадвартай газруудад арга зүйн дагуу	Хийгдсэн	
Усан орчин					
Усан дахь эрдэс бодисууд, химийн найрлага	Унд ахуйн хэрэглээний ус Ажилчдын гал тогоо	Жилд 1 удаа	Усны дээж авах сав, хээрийн хэмжилтийн багаж (рН/EC/TDS meter, TDS-3) зэргийг ашиглан дээж авах	Хийгдсэн	Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ. MNS 0900:2018 Газрын доорх усыг

**БАЯН ТАЛ НЭРТЭЙ ЭЛС ХАЙРГАНЫ ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

“Ката” ХХК

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээ явуулах арга хэлбэр, хэрэглэх багаж төхөөрөмж	Зардал, сая.төг /1 жил/	Баримтлах стандарт ба арга, аргачлал
(Анионууд: Cl ⁻ , SO ₄ ⁻ , NO ₂ ⁻ , NO ₃ ⁻ , CO ₃ ⁻ , HCO ₃ ⁻ -Катионууд: Na ⁺⁺ +K ⁺ , Ca ⁺⁺ , Mg ⁺⁺ , NH ₄ ⁺ , Fe ⁺⁺ , Fe ⁺⁺⁺ , pH, EC, TDS, Физик чанар: тунгалаг, үнэр, тунадас, өнгө, амт)			ба дээжийг итгэмжлэгдсэн лабораторид өгч шинжлүүлнэ		бохирдохоос хамгаалах ерөнхий шаардлага. MNS 3342:1982 Гадаргуугийн ба газрын доорх усыг эрдэс бордооны бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлага. MNS 3597:1983 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага. MNS 4586:1998
	Хөрсөн бүрхэвч				
Ялзмаг, урвалын орчин (pH), давсжилт, карбонат (CaCO ₃), хөдөлгөөнт кали (K ₂ O), хөдөлгөөнт фосфор (P ₂ O ₅), Шингээгдсэн сууриуд Ca, Mg	Шимт хөрсний овоолго, , ажилчдын тосгон	Хөндлөнгийн хяналт шинжилгээг жилд хоёр удаа	Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээ задлан	Хийгдсэн	Хээрийн ажиглалт, хэмжилт, бичиглэлийг хяналтын судалгаанд сонгон авсан хөрс бүр дээр хийх, фото зургаар баталгаажуулах Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүй үзүүлэлт, бохирдлыг үнэлэх. MNS 3297:2019 Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд. MNS 3298:1991
Механик бүрэлдэхүүн, чулуу, чийг, амь чийг, эзлэхүүн жин				Хийгдсэн	Хөрсний чанар. Хөрсөнд агуулах бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 5850:2019
Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн агууламж				- Ил уурхайн олборлолтын орчимд - Тээвэрлэлтийн замын орчимд - Түлшний агуулах	
	Амьтны аймаг				
Амьтны зүйлийн бүрдэл, тархалт байршлын судалгаа хийж, үнэлэлт дүгнэлт өгөх	Төслийн талбайн болон ойр орчмын өндөрлөг цэгүүдэд	Жил бүр 7-8 сард нэг удаа	Биологийн олон янз байдлын мониторинг судалгааны аргазүй. БОНХЯ, 2012.	Хийгдсэн	Биологийн хүрээлэнгийн баталсан арга зүй

**БАЯН ТАЛ НЭРТЭЙ ЭЛС ХАЙРГАНЫ ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

“Ката” ХХК

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээ явуулах арга хэлбэр, хэрэглэх багаж төхөөрөмж	Зардал, сая.төг /1 жил/	Баримтлах стандарт ба арга, аргачлал
Ургамлын аймаг					
Ургамлын газрын дээд болон доод массын дээжлэлт хийх	Орчны бохирдолд өртөж болзошгүй цэг болон алслагдсан цэгүүдийг сонгон авч ургамлын дээд болон доод массын дээж авч лабораторийн шинжилгээнд явуулж, агууламжийг харьцуулан гаргах	Жилд удаа сард) нэг (6-7	Батлагдсан арга зүйн дагуу жилд хоёр удаа	Хийгдсэн	Ургамлан нөмрөгт нөлөөлөх нөлөөлөл, үнэлгээ бүлгийн хээрийн судалгааны аргазүйн дагуу. “Эвдэрсэн газрыг нөхөн сэргээлт хийхэд тавигдах ерөнхий шаардлага. MNS 5914:2008. “Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага MNS 5918:2008

“Ката” ХХК

1.6 БОМТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ

Төсөл хэрэгжүүлэгч Ката ХХК жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайланг хүргүүлэх ба төсөл хэрэгжих аймгийн байгаль орчны газар, сумын Засаг даргын тамгын газарт тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ.

Хүснэгт 10. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Байгаль Орчин, Уур амьсгалын өөрчлөлтийн яам	Тайлангийн эх хувь, албан бичгийн хамт	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр дэлгэрэнгүй илэрхийлэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна	Жилийн эцэст	Цаашид төлөвлөгөөнд шинээр тусгах зүйлс	Улаанбаатар хот
Налайх дүүргийн ИНХ	Тайлангийн эх хувь, албан бичгийн хамт	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр илэрхийлэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна	Хагас жил, жилийн эцэст	Цаашид анхаарах зүйлс, Хамтран ажиллах	ИНХ

БАЯН ТАЛ НЭРТЭЙ ЭЛС ХАЙРГАНЫ ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

“Ката” ХХК

НАЛАЙХ “ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ” ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Ц.ЭРБОЛ



ХОГ ХАЯГДЛЫН ТӨЛБӨРТ
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

25 09 30.
20... оны ... сарын ... -ны өдөр

№

Налайх дүүрэг

Иргэн, ААНБ-ын нэр	Ката ХХК
Регистрийн дугаар	5931312
Үйл ажиллагаа явуулж буй объектын оноосон нэр:	
Үйл ажиллагааны чиглэл	Эл хайрга ол-н
Иргэн, ААНБ-ын хаяг	Зр дорно
ААНБ-ын холбогдох утас	88881233
Газар зүйн хязгаарлалт	Налайх дүүргийн ... хороо
Данс: 5749062084	Хаан банк
Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төрөл	Тусгай
Төлбөрийн нөхцөл	Дансаар
Гэрээний хугацаа	2025-9-30 - 2025-12-31

Энэхүү гэрээ нь Монгол Улсын хог хаягдлын тухай (шинэчилсэн найруулга) хууль, Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах, ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх харилцааг зохицуулах, аж ахуйн нэгж байгууллага, ХХЭрхлэгч нэг бүрийн үүрэг хариуцлагыг тодорхойлж дүгнэх, Эрүүл ахуйн тухай хууль, Нийслэлийн ИТХ-ийн Тэргүүлэгчдийн 2009 оны 63-р тогтоолоор батлагдсан “Хот тохижилт, цэвэрлэгээний талаар албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дагаж мөрдөх журам”, “Журамд өөрчлөлт оруулах тухай” Нийслэлийн ИТХ-ийн 2012 оны 61-р тогтоол, Налайх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 19/04 дугаар тогтоол болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн баримтална.

Нэг талаас Налайх дүүргийн Тохижилт Үйлчилгээ ОНӨААТҮГ /цаашид “хог хаягдал тээвэрлэгч” гэх/ нөгөө талаас
/иргэн, аж ахуй нэгж байгууллагын нэр/

Төлөөлж /цаашид “Хог хаягдал тээвэрлүүлэгч” гэх
ажилтай овогтой нар харилцан
тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү гэрээ нь Налайх дүүргийн ...-р хорооны нийтийн эзэмшлийн зам талбай, айл өрх, аж ахуй нэгж байгууллагын хог хаягдлыг цуглуулж, ачиж тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт хүргэж хариуцсан бүсийг хог хаягдалгүй цэвэр байлгахад оршино.

“Ката” ХХК

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ГАЗАРЗҮЙ, ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН
ХӨРСНИЙ ЭКОЛОГИЙН ЛАБОРАТОРИ
Хаяг: Баруун Сэлбийн 15, 4-р хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар-15170

ХӨРСНИЙ ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

Дээж шинжлүүлсэн байгууллага: “КАТА” ХХК

Дээж авсан газрын нэр: Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 5-р хороо

Шинжилгээний хийсэн огноо: 2025 оны 07 дугаар сарын 28.

Хүснэгт 1. Хөрсний химийн шинж чанар

